4	Яамны 2024 оны үйл ажиллагааны үр дүн, 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтгэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	- Тайлангийн тоо - Холбогдох байгууллагад хүргүүлэх	2024 оны ХШҮ-ний тайлан	-1 -1	<p>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмын 9.1-д заасны дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, запуучуудын яамны 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд 1. Сайдын эрхлэх асуудлын хүрээний 9 төрлийн 197 тогтоол шийдвэрийн 381 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 88.5 хувиар үнэлсэн. 2. “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 85.76 хувиар үнэлсэн. 3. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан ССАЖЗ-ын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 2 зорилт, 13 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 75 хувиар үнэлсэн. 4. Засгийн газрын 2018 оны “Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт батлах тухай” 55 дугаар тогтоофын хавсралтад Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээнд соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, шинээр болон сэргээн тавьсан бүтээл, шинээр баригдсан соёл, урлагийн байгууллага, сэргээн засварлагдсан түүх соёлын дурсгалт зүйлийн талаарх батлагдсан 5 үзүүлэлтийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн дүнг зорилтот түвшинтэй харьцуулж үнэлэхэд 91.8 хувьтай үнэлгэдсэн. 5. Яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд тусгагдсан бодлогын баримт бичгийн 24 зорилтын 197 арга хэмжээ, хуулиар тусгайлан болон нийтлэг олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 10 зорилтын 21 арга хэмжээ, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 5 зорилтын 56 арга хэмжээ нийт 24 зорилтын 197 арга хэмжээний биелэлтийг хяналтад авч, хэрэгжилтийн гүйцэтгэлийг 91.27 хувиар үнэлсэн. 6. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх 14 арга хэмжээ, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 12 арга хэмжээний биелэлтийг 100 хувиар үнэлсэн.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 1 файл</p>	3-р сар, 12-р сар	100%
5	Сайдын эрхлэх асуудлын хүрээний	- Тайлангийн тоо-2 -	2024 оны ХШҮ-ний тайлан	-1 -1	1. Сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа 26 байгууллага нь “Салбарын Хяналт-шинжилгээ, үнэлгээний щахим систем”-д гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 зорилтын	3-р сар, 12-р сар	90%

	агентлаг, аймаг, нийслэлийн СУАЖЗГ, харьяа 25 байгууллагын 2025 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	www.m os.igovernmen t.mn цахим системд үнэлсэн байна.			хүрээнд 1064 арга хэмжээг төлөвлөн батлуулж, тайлагнасан байна. • Захиргааны болон салбарын хэмжээний нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг уурэг бүхий 3 байгууллагын дундаж үнэлгээ 90.8 хувьтай; • Театрын байгууллагуудын дундаж үнэлгээ 89.4 хувьтай; • Музейн байгууллагын үнэлгээ 91,06 хувьтай; • Номын сангудын дундаж үнэлгээ 89.7 хувьтай • Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн дундаж үнэлгээ-91.8 хувьтай • Хамгаалалтын захиргаадын дундаж үнэлгээ-86.6 хувьтай үнэлэгдэв. Хяналт, шинжилгээний дүнгээр харьяа байгууллагуудын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт тооцсон 1064 арга хэмжээний дундаж үнэлгээ 90.38 хувьтай буюу 4.5 оноотой цаашид “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн. 2. ХШҮ-ний тайланг сайд, төрийн нарийн бичгийн даргад 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдөр илтгэх хуудсаар танилцуулсан.. 3. Харьяа байгууллагын удирдах ажилtnы зөвлөгөөн болсон 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг танилцуулан, цаашид анхаарах зорилт, арга хэмжээний талаар зөвлөмж өгсэн. 4. Харьяа байгууллагуудын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд ХШҮ хийн нэмэлтээр харьяа болон орон нутгийн соёл урлагийн газруудаас хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх нарийвчилсан статистик тоо, мэдээлэл, санхүүгийн хяналт шалгалтын дүн мэдээг нэгтгэн бэлтгэв.	Хавсралт: 1 файл		
6	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Тайлангийн тоо	2024 оны ХШҮ-ний тайлан	-1	Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 6 зорилтод хамаарах 677 арга хэмжээний 2024 оны биелэлт нь 85.8 хувь буюу 4.29 оноотой “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн дүгнэлт өгсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар яамны газар, нэгжийн удирдлагад 2 зөвлөмж, аймгийн ЗДТГ-т 4 зөвлөмж хүргүүлсэн.	Хавсралт: 2 файл	3-р сар	100%

7	Дорнод, Хэнтий, Баян-Өлгий, Увс аймгийн СУАЖКГ, БСТГ, театр, музей, номын сан, соёлын төвийн 2024-2025 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	- Тайлантайлан гийн тоо	Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийн СҮГ-т хийсэн хяналт шалгалтын тайлантайлан	-1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.2.15, 4.2.16, 4.2.17, 4.2.18, 4.2.21, 4.2.22-т тусгасан арга хэмжээний дагуу • Баян-Өлгий, Увс, Хэнтий, Дорнод аймгийн харьяа байгууллагуудад дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; • Баян-Өлгий, Увс, Хэнтий, Дорнод, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн харьяа байгууллагуудын 360 албан хаагчдад хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод хяналт шалгалтын чиглэлээр сургалт зохион байгуулах хөтөлбөрийг боловсруулсан. Дээрх ажлыг хэрэгжүүлснээр Үндэсний аудитын газрын 2025 оны 1023/A0111241, СНАГ-2025/020/НА-СГА-ТЕЗ дугаартай “Зөрчил арилгах тухай” албан шаардлагаар егөгдсөн санхүү, нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулах үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ач холбогдолтой. Орон нутагт албан томилолтоор ажиллах зардлын эрх нээгдэхээр буюу 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс Хэнтий, Дорнод аймагт ажиллахаар хүлээгдэж байна.	6-р сар, 12-р сар	30%
Хавсралт: 1 файл							
8	Салбарын нээлттэй өгөгдлийг нийтлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих	Үнэлсэн харьяа байгууллагын тоо	Үнэлсэн харьяа байгууллагын тоо-26	-1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт хангах ажлын хүрээнд Сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа 26 байгууллагын ил тод нээлттэй мэдээллийг shilen.gov.mn цахим хуудсанд тайлагнасан 25 байгууллагын 1 дүгээр улирлын тайланг үнэлэн ЦХХХЯ-нд хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнгээр харьяа байгууллагуудын дундаж үнэлгээ 68 хувьтай, 1 байгууллага хугацаа хоцроосон байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар илэрсэн алдаа дутагдлыг арилгах талаар 4 зөвлөмжийг харьяа байгууллагын удирдлагад 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 12/985 дугаар албан бичгээр хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. Үүнд: Нэг. Байгууллагын цахим хуудас, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулдаг мэдээллийг хуулийн хугацаанд тогтмол шинэчлэн, байгууллагын мэдээллийн самбарыг тухай бүр шинэчилсэн тухайгаа зургаар баримтжуулан shilen.gov.mn цахим хуудасны харгалзах талбарт зөв холбон байршуулах; Хоёр. “Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдал” талбарт хууль тогтоомж болон тухайн байгууллагын дотооддоо баталсан хүний нөөцийн чиглэлээрх журам, ажлын байрны сүл орон тооны зарыг мэдээлэх; Гурав. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	100%

					мэдээллийн талбарт үзвэр үйлчилгээний үнэ тариф, зар мэдээ, зохион байгуулсан арга хэмжээний хөтөлбөр, тайлан зэргийг байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулан холбоосыг shileen.gov.mn цахим хуудсанд мэдээлэх; Дөрөв. Бусад мэдээллийн ил тод байдлын талбарт байгууллагын эзэмшиж буй газрын гэрчилгээ, кадастрын зураг, ажлын байрны түрээсийн гэрээ, байгууллагын фоуны өмчийн гэрчилгээ, тухайн улирлын өргөдөл, гомдолын тайланг PDF файлаар байршуулах.		
					Хавсралт: 2 файл		
9	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах.	Тайлангийн тоо	-	-1	<p>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон харьяа 5 байгууллагад Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж дууссан 2, хэрэгжүүлж байгаа 5, хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа 1 төслийн хэрэгжилтийн үр дүн, явцын байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 90.8 хувийн хэрэгжилттэй байна. № Төслийн нэр Төслийн хугацаа Төслийн үнэлгээ Хэрэгжүүлэгч байгууллагын нэр 1. Соёлын ёиет бус өвийг хамгаалах, чадавхыг бэхжүүлэх, үндэсний сургагч ёбагш бэлтгэх 2024-2025 100% СӨҮТ 2. Монголын кино урлагийн салбарын суурь судалгаа 2024 90% КҮЗ 3. Үндэсний номын сангийн хэрэгжүүлж буй Төвд хэлт ном, судрыг каталогжуулан цахимжуулах 2018-2025 88% ҮНС 4. Гал түймэрт өртөж гэмтсэн уран зургийг сэргээн засварлах лаборатори байгуулах 2022-2023 100% УЗГ 5. Чингис хаан Үндэсний музейн дижитал контент хөгжүүлэлт болон үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх" төсөл ЧХҮМ 6. "Мэргэн Тоньюокүү музей" цогцолборын төсөл 2018-2025 80% ССАЖЗЯ 7. Монголын аялал жуулчлалын сургалтын төв байгуулах, салбарын хүний нөөцийн чадавхын бэхжүүлэх төсөл 2019-2024 98% ССАЖЗЯ 8. Төгтвортой аялал жуулчлал төсөл 2019-2026 80% ССАЖЗЯ Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар З зөвлөмжийг холбогдох нэгжийн даргад хүргүүлсэн. Үндэсний номын сангийн хэрэгжүүлж байгаа төслийн гэрээний хугацаа дуусаж байгаа тул цаашид Төвөд судрын бүртгэлийн ажлыг үргэлжлүүлэх хөрөнгийг шийдвэрлэх. Төсөл хэрэгжүүлэгч нэгж, байгууллагуудад 1. төслийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон жил бүр</p>	6-р сар	100%

					хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх. 2. Төслийн санхүүгийн тайлан гаргаж, хөрөнгийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах.		
Хавсралт: 1 файл							
3.2. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
10	Мэдээллийн ил тод байдлыг хангаж дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг цаглаварт хугацаанд яамны цахим хуудсанд байршуулах	Яамны цахим хуудсанд байршуулсан тайлангийн тоо	тайлангийн тоо-10	-1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны mocsty.gov.mn цахим хуудсанд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээний 8 тайлан, дотоод аудит, хяналт шалгалтын 2024 онд гүйцэтгэсэн 11 тайлан, 2025 оны эхний хагас жилийн дүнгээр гүйцэтгэсэн 3 тайланг байршуулан Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэн олон нийтэд мэдээлсэн.	6-р сар, 12-р сар	100%
					Хавсралт: 1 файл		
11	Дээд шатны болон хөндлөнгийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнах.	Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг тайлагнасан эсэх	ҮАГ-аас өгсөн 2023 оны зөвлөмжийн биелэлтийн тайлан	-	Үндэсоний аудитын газраас хийсэн "Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл" сэдэвт 2 гүйцэтгэлийн аудитын тайлангаар ирүүлсэн 6 зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20.3 дахь заалтын дагуу ҮАГ-т Сайдын 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 1/978, 1/979 дүгээр албан бичгээр хүргүүлж, зөвлөмжийн нэгдсэн санд бүртгэж хяналтад авсан. 2024 оны 12 дугаар сард гүйцэтгэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний 4 тайлангаар яамны газар, хэлтэс, харьяа байгууллагын удирдлагад хүргүүлсэн 11 зөвлөмж, 2025 оны эхний хагас жилд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний 2 тайлангаар хүргүүлсэн 5 зөвлөмжийг зөвлөмжийн нэгдсэн санд бүртгэж хяналтад авсан. Зөвлөмжийн биелэлт гаргаж ирүүлэх хугацаа болоогүй байна.	6-р сар, 9-р сар	70%
					Хавсралт: 3 файл		
12	Хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дотоод аудитын хүрээнд хөтөлбөр,	- Сургалтын тоо - Хамрагдсан хүний тоо	2024 онд зохион байгуулсан сургалт -1	-1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын төрийн захиргааны болон төв, орон нутгийн харьяа байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Удирдлагын академийн Б байранд зохион	3-р сар, 9-р сар	100%

	арга хэмжээний үр дүн, үр нөлөөг тодорхойлох арга зүйд сургах сургалт зохион байгуулах.				<p>байгуулав. Сургалтад хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх болон салбарын харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, тайлагнаанд дүн шинжилгээ хийх арга зүй, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтооолоор баталсан журмыг шинэчлэн баталсан З журамтай танилцах, үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах асуудал зэрэг сэдвийн хүрээнд сургалт явагдлаа. Мөн салбарын хэмжээнд дотоод хяналт шалгах хийх арга зүй олгох лекцийг ХШУДАГын дарга Д.Түмэндэмбэрэл тавьж, төсөв санхүүгийн чиглэлээр дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах талаар дадлага ажлыг ахлах шинжээч Ц.Алтанхуяг, санал, өргөдөл, гомдлын мөрөөр дотоод хяналт хийх талаарх дадлага ажлыг дотоод аудитор Б.Лхагвасүрэн нар зааж, аргазүйн зөвлөгөө өгсөн. Сургалтыг Засгийн Газрын Хяналт хэрэгжүүлэх газрын ахлах референт референт М.Баярмаа, Ш.Бумаажав, Удирдлагын академийн ахлах багш Ё.Батсүх настай хамтран зохион байгууллаа. Сургалтад зарцуулахаар батлагдсан 8.0 сая төгрөгийн төсвийг дараах байдлаар зарцуулсан болно. Үүнд</p> <ul style="list-style-type: none"> • Сургалтыг зохион байгуулсан лед дэлгэц, тоног төхөөрөмжийн түрээсийн зардал, сургалтын гэрчилгээний зардлыг хариуцсан "АРПО анд" ХХК -1,400.0 мянган төгрөг; • Сургалтад оролцогчдын цайны завсарлагааны зардлыг хариуцсан "Данада очир" ХХК -5,400.0 мянган төгрөг <p>Хавсралт: 1 файл</p>		

3.3. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ

13	Газрын 2024 оны төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Батлагдсан төлөвлөгөөний тоо Тайлангийн тоо	2020-2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлан	-1	Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 -д заасны дагуу хууль тогтоомжид заасан өөрийн нэгжийн эрхлэх асуудлын хүрээний чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор 2025 оны нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 5 зорилт, 24 арга хэмжээ, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 1 зорилт 3 арга хэмжээг тусган боловсруулж Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 21.7 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын 3.1 дэх заалтын дагуу Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулан албажуулсан. Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг журмын 3.3-д заасны дагуу хагас	1-р сар, 6-р сар, 12-р сар	100%
----	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------	----------------------------------------------	----	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------	------

						жилийн байдлаарх тайланг гаргаж 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр цахим системд тайлагнасан.		
						Хавсралт: 1 файл		
14	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	Батлагдсан төлөвлөгөөний тоо Тайланийн тоо	2020-2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	-1		<p>Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 -д заасны дагуу хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 3 зорилт, 14 арга хэмжээ, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 2 зорилт 7 арга хэмжээ, мэдлэг чадвараа дээшлүүлэх 1 зорилт, 1 арга хэмжээг тусган боловсруулж Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын газрын 2.4 дэх заалтын дагуу нэгжийн даргаар баталгаажуулан албажуулсан. Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж эхний хагас жилийн байдлаар хугацаа болсон 3 зорилт, 17 арга хэмжээний биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр цахим системд тайлагнасан.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 1 файл</p>	1-p сар, 6-p сар, 11-p сар	100%
15	Авлигын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зэрчлийн урьдчилан сэргийлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	ХАСХОМ бөглөж баталгаажуулсан маягт	2020-2023 мэдүүлэг	-1		<p>Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 заасны дагуу Төрийн албан хаагчийн 2024 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр meduuleg.iaac.mn системээр гаргаж мэдүүлсэн Дотоод аудит, хяналт шалгалтын ажил гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах, удирдамж батлуулах үедээ 4 удаа хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж Хууль эрх зүйн хэлтсийн ажилтанд өгч бүртгүүлсэн. Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээчийн албан тушаалд шилжин ажиллах шаардлагаар Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын урьдчилсан мэдүүлгийг 2025 оны 01 дугаар сарын 07-ны өдөр meduuleg.iaac.mn системээр гаргаж мэдүүлсэн.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 1 файл</p>	2-p сар	100%
16	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон	2024, 2025 онд хөтөлсөн баримт бичгийг	2024 онд хөтөлсөн баримт бичгийг	-1		Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4.1, 35.4.7 заасан заалт, салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээчийн ажлын	3-p сар	100%

	тэдгээртэй нийшүүлэн гаргасан хууль тогоомжийг хэрэгжүүлэх.	хэргүүдийг архивын үндсэн зааврыг баримтлан, дотоод товьёг үйлдэж, яамны архивд хүлээлгэн өгсөн эсэх	архивласан		байрны тодорхойлолтын 5 дугаар зорилтын 8-д заасны дагуу дотоод аудит, хяналт шалгалтын 2023-2024 онд бэлтгэсэн тайлан, ажлын баримтыг архивын нэгж болгон эмхлэн боловсруулж архивын ажилтанд 2025 оны 05 дугаар сарын 12-ндийт 13 архивын баримтыг хүлээлгэн өгсөн. Хавсралт: 1 файл		
--	-------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------	--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		Эхэлсэн, дууссан хугаца
1	2	3	4	5	6	7	
1	Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллах	Сонгон шалгаруулалт зохион байгуулсан тоо	-	1	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/43 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар томилогдсон. Цахим үйл ажиллагааны аюулгүй байдал болон албан хэрэгцээний программ хангамжийн лиценз худалдан авах ССАЖЗЯ/2025/04 дугаарын тендер шалгаруулалтыг цахим системээр 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зарлан, тендерийг хүлээн авахад 3 оролцогч тендерийн баримт материал ирүүлснийт 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр үнэлгээний хорооны гишүүдийн хурлаар үнэлж Инфосолюшион ХХК-ны ирүүлсэн тендерийн үнийн санал нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасны дагуу хамгийн сайн үнэлэгдсэн тул гэрээ байгуулах зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлж, гэрээг байгуулсан.	2025 оны 05-р сарын 01-ээс 30- ны өдөр	100
2	Ажил хүлээлцэх ажлын хэсгийн гишүүнээр ажиллах	Ажлын хэсэгт ажилласан тоо	-	1	Сайдын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн Б/19 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын албан ажлыг тус газрын Соёлын өвийн хэлтсийн дарга Э.Цэнд-Аюушд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүлээлцсэн үйл ажиллагаанд оролцсон.	2025 оны 05-р сарын 30-ны өдөр	100

3	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүнээр ажиллах	Ажлын хэсэгт ёжилласан тоо	1	1	<p>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-1/2389 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдэлээрээ анхны өргтөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон 69 илэрийн нийт 511,084,653.97 (тавин нэгэн сая наян дерөв мянга зургаан зуун тавин гурван төгрөг өрэн долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулж акталж устгасан баримтыг бурдуулж, тайланг ТӨБЗГ-т хүргүүлсэн.</p>	:2025 оны 03-р сарын 25-ны өдөр	100
4	Эрхэүйн баримт бичигт санал өгөх	Санал өгсөн тоо	-	5	<p>Дотоод албан бичгээр яамны нэгжүүдээс ирүүлсэн дүрэм, журамд санал авах тухай 5 бичгийн дагуу зарчмын нэмэлт өөрчлөлт тусгах 6 заалт, найруулгын өөрчлөлт хийх 19 санал гаргаж хүргүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас ирүүлсэн НҮБ-ын Хүн амын сангаас бэлтгэсэн тайлангийн өмнөх үгийн төсөлд 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдөр найруулгын чанартай санал өгсөн. • Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас боловсруулж буй Сайдын тушаалаар батлагдах “Допингийн эсрэг үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн төсөлд зарчмын өөрчлөлтийн заалт нэмэх тухай 2 санал, найруулгын шинжтэй 9 санал өгсөн. • Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас боловсруулж буй Сайдын тушаалаар батлагдах “Олимп, паралимпын наадамд оролцох үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлыг зохион байгуулалттаар хангах үндэсний хорооны дүрэм”-ийн төсөлд зарчмын өөрчлөлтийн заалт нэмэх тухай 3 санал, найруулгын шинжтэй 5 санал өгсөн. • Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас боловсруулж буй Хөгжмийн зохиол, Дүрслэх урлагын шилдэг бүтээл шалгаруулах, улсын санд худалдан авах, хадгалах, ашиглах журамд жайруулгын шинжтэй 5 санал өгсөн. • Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас боловсруулж буй Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга, байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг хөнгөлөлтэй нөхцөлөөр ашиглаулах журамд зарчмын өөрчлөлтийн 1 заалт нэмэх тухай санал өгсөн. 	2025 оны 2 дугаар улирал	100

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт			Эхэлсэн, дууссан хугаца
			1	2	3	4	5	
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг өзэмших, тасралтгүй хөгжүүлэх								
1	Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр сургалтад хамрагдах	Гадаад, дотоодын байгууллагаас зохион байгуулсан хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр сургалтад хамрагдах	2024 онд сургалтад удаа хамрагдсан	-1 :2	Tайлант хугацаанд дээд шатны байгууллагаас зохион байгуулсан 3 удаагийн сургалтад 4 өдөр хамрагдсан байна. Үүнд <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас олон улсын үнэлгээний цолц системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд үндэсний үнэлгээний чадамжийн индексийн талаарх мэдээлэл, судалгааг бөглөх талаар заавар өгөх цахим сургалтад хамрагдсан. - Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Авлигын эсрэг сургагч багш" бэлтгэх сургалтад 2025 оны 03 дугаар сарын 27, 28-ны өдөр хамрагдаж, 16 сэдвээр лекц сонсож сургагч багшийн гэрчилгээ авсан. - Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Хөгжлийн үнэлгээний байгууллагатай хамтран зохион байгуулсан "Монгол Улсын бодлогын үнэлгээний чадавхын индекс" тогтоох үнэлгээний үр дүнг танилцуулах чуулга уулзалтад оролцсон. 	6-р сар, 12-р сар	100%	

Хавсралт: 2 файл

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч Цэвэгдоржийн Алтанхуяг /...../
Огноо: do 28.06.10

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
дараын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

**САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ
Ц.АЛТАНХУЯГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭЖЛИЙН ТҮВШНИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам**

Нэгжийн нэр: **Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар**

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсэн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн огноо
	1	2	3		
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

Зорилт 1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ

1	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан яамны эрхлэх асуудлын хүрээний арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх.	42	10	52	
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	60	10	70	
3	Сайдын дангаар болон бусад захиргааны байгууллагатай хамтарч баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ үнэлгээ хийх.	60	10	70	
4	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	60	10	70	
5	Яамны 2024 оны үйл ажиллагааны үр дүн, 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	60	10	70	
6	Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, нийслэлийн СУАЖЗГ, харьяа 25 байгууллагын 2025 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	54	10	64	
7	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	60	10	70	
8	Дорнод, Хэнтий, Баян-Өлгий, Увс аймгийн СУАЖГ, БТСГ, театр,	18	5	23	

	музей, номын сан, соёлын төвийн 2024-2025 бны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.				
9	Салбарын нээлттэй өгөгдлийг нийтлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих	60	10	70	
10	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах.	60	10	70	

Зорилт 2. Мэдээллийн ил тод байдлыг хангах

11	Мэдээллийн ил тод байдлыг хангаж дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг цаглаварт хугацаанд яамны цахим хуудсанд байршуулах	60	10	70	
12	Дээд шатны болон хөндлөнгийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнах.	42	10	52	
13	Хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дотоод аудитын хүрээнд хөтөлбөр, арга хэмжээний үр дүн, үр нелөөг тодорхойлох арга зүйд сургах сургалт зохион байгуулах.	60	10	70	

Зорилт 3. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ

14	Газрын 2025 оны төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	60	10	70	
15	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулэх, төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд нь гэргэж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	60	10	70	
16	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	60	10	70	
17	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль төгтөөмжийг хэрэгжүүлэх.	60	10	70	

Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт

Дундаж оноо:	64.76	
--------------	-------	--

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
-----	----------------------------------	--------------------------------	---------------------------	-----------------------------------------------------------

	1	2	3	4
1	Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр сургалтад хамрагдах	100	15	
	Дундаж оноо:		15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 очоо)		Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
		1	2	
1	Хандлага, ёс зүй		7	
2	Дүн шинжилгээ хийх		7	
3	Асуудал шийдвэрлэх		7	
4	Хариуцлагатай байдал		7	
5	Ажлын цаг ашиглалт		7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)				
6	Мэргэжлийн ур чадвар 1.			
7	Мэргэжлийн ур чадвар 2.			
8	Мэргэжлийн ур чадвар 3.			
	Дундаж оноо:		7	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 очоо)	
		1	2
1	Хандлага, ёс зүй		7,75
2	Багаар ажиллах		7,75
3	Харилцаа		7,75
	Дундаж оноо:		7,75

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	64,7
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7,75
5	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
	Нийт оноо:	94,5

93,5

Үнэлгээ өгсөн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Нэгжийн дарга

.....
(гарын үсэг)

.....
(Д.ТҮМЭНДЭМБЭРЭЛ)
(албан хаагчийн нэр)

.....
(огноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

АХЛАХ ШИНЖЭЭЧ
(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:

.....
(гарын үсэг)

.....
(Ц.АЛТАНХУЯГ)
(албан хаагчийн нэр)

.....
do 25.06.17 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(Д.ТҮМЭНДЭМБЭРЭЛ)
(албан хаагчийн нэр)

.....
(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ЯАМНЫ ХҮНИЙ НӨӨЦ,
ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ
ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧИЙН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(Ч.ОСГОНБАТ)
(албан хаагчийн нэр)

.....
do 25.06.17 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(С.ОЮУНБИЛЭГ)
(албан хаагчийн нэр)

.....
(огноо)



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Ахлах мэргэжилтэн - Дотоод аудитор (Биеийн тамир, спорт, залуучууд), Ганбаатар Шүрэндолгор

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугаца	Биелэ лтийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт					
	1	2	3	4	5	6	7			
1.1. ЯАМ, АГЕНТЛАГ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРСДЭЛД СУУРИЛСАН ДОТООД АУДИТЫГ ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ										
1	Арга хэмжээ 1.1. Эрсдэлд суурилсан дотоод аудитын дунд хугацааны болон жилийн төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах.	Төлөвлөгөөний хэрэгжилт	2022-2024 оны дунд хугацааны төлөвлөгөө, 2024 оны жилийн төлөвлөгөө	30%	Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.1 дэх заалт, Сангиин сайдын 2019 оны 29 дүгээр тушаал "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 4.1, 4.1.1, 3.6-д тус тус заасны дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын Сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар " Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө ", дөрөвдүгээр хавсралтаар " Дотоод аудитын 2025 оны төлөвлөгөө " тус тус батлуулсан. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг 2025 оны эхний хагас жилд 3 байгууллагад хийхээр төлөвлөсөн ба 2 байгууллагын аудит хийгдэж тайлан, дүгнэлтийг хүргүүлсэн ба 1 аудит 80%-тай явагдаж байна. Төлөвлөгөөт аудит, санхүүгийн хяналт шалгалтаар нийт 6.3 сая төгрөгийн акт, 2,505.0 сая төгрөгийн 7 заалттай албан шаардлага, 3,068,1 сая төгрөгийн 16 зөвлөмж, 9 албан тушаалтан сахилгын шийтгэл оногдуулах санал хүргүүлж Авлигатай тэмцэх газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 01/517 дугаар албан бичгээр дотоод аудитаар илэрсэн 1 асуудлыг шийдвэрлүүлэх саналыг хүргүүлсэн. Төлөвлөгөөт дотоод аудитаар өгсөн 2025 оны эхний хагас жилийн шийдвэрийн (акт, албан шаардлага, зөвлөмж) хэрэгжилтийн явц 77%-тай байна. Төлөвлөгөөт аудитын тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн	6-р сар, 12-р сар	100%			

						албаны зөвлөл, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд тус тус хүргүүлсэн.		
						Хавсралт: 3 файл		
2	Арга хэмжээ 1.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны объектын эрсдэлийн үнэлгээ хийх	Эрсдэлийн үнэлгээний мэдээллийн сангийн тоо	2024 оны эрсдэлийн үнэлгээний мэдээллийн сан	1	<p>ССАЖЗ-ын Сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2025 оны 03 дугаар сарын 28-ны 01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар "Эрсдэлийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт" гуравдугаар хавсралтаар "Харьяа байгууллагын 2025 оны эрсдэлийн үнэлгээ"-г тус тус баталсан.</p> <p>Эрсдэлийн үнэлгээнд сайдын эрхлэх асуудлын хүрээний 82 байгууллагыг хамруулсан. Эрсдэлийн үнэлгээг Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаал "Улсын салбарын дотоод аудитын аргачлал", ССАЖЗ Сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2025 оны 03 дугаар сарын 28-ны 01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт "Эрсдэлийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт"-ийн дагуу төсвийн хэмжээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэх удирдлага болон санхүүгийн ажилтны тогтвортой байдал, дотоод аудитын үр дүн, хөндлөнгийн аудитын үр дүн, шилэн дансны бүртгэл хөтлөлт гэсэн 6 шалгуур, үзүүлэлт тус бүр 1-5 оноогоор үнэлэн, 14 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй, 15-20 оноо авсан бол дунд эрсдэлтэй, 15-20 оноо авсан бол дунд 21-30 оноо авсан бол их эрсдэлтэй гэж эрсдэлийн шалгуурыг баталсан. Дотоод аудитын хорооны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Харьяа байгууллагын 2025 оны эрсдэлийн үнэлгээ"-гээр <i>Их эрсдэлтэй-23 байгууллага, дунд эрсдэлтэй-46 байгууллага, бага эрсдэлтэй-13 байгууллага</i> байна гэж дүгнэгдлээ.</p>	4-р сар	100%	
3	Арга хэмжээ 1.6. Дорнод, Хэнтий, аймгийн СУАЖГ, БСТГ, театр, музей, номын сан, соёлын төвийн 2024-2025 оны төсвийн зарцуулалт, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалтад дотоод	Тайлангийн тоо	Харьяа 14 байгууллагад аудит хийсэн тайлан	2	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.2.15, 4.2.21, 4.2.22 -т тусгасан арга хэмжээний дагуу Хэнтий, Дорнод аймгийн харьяа байгууллагуудад дотоод аудит хийх удирдамжийг боловсруулан төрийн нарийн бичгийн дарга болон сайдад илтгэх хуудсаар танилцуулсан. Дотоод аудитын удирдамж, томилолгоор ажиллах тушаалын зардлыг сайдаас төрийн нарийн бичгийн дарга луу эрх шилжүүлхээр шийдвэрлэсэн. Мөн зүүн бүсийн удирдах ажилтны зөвлөгөөнтэй уялдуулан зохион байгуулахаар хүлээгдэж байна.	6-р сар, 12-р сар	30%	

	аудит хийх.					Хавсралт: 1 файл		
4	Арга хэмжээ 1.7. Яамны 2024-2025 оны төсвийн зарцуулалт, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалтад дотоод аудит хийх.	Тайлангийн тоо	-	1	<p>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.2.19-д заасан арга хэмжээ, Дотоод аудитын 2025 оны төлөвлөгөөны дагуу Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яамны/аппарат/ 2024 он, 2025 оны эхний хагас жилийн төсвийн зарцуулалт, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалтад дотоод аудит хийх, удирдамж боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Сайдаар батлуулан дотоод аудитыг гүйцэтгэж байна.</p> <p>Төлөвлөгөөт аудитаар төрийн нарийн бичгийн даргын 2024 он, 2025 оны I улирлын байдлаарх нийт 27,486.3 сая төгрөгийн 267 тушаалаас 5,147.7 сая төгрөгийн 50 тушаал санхүүгийн анхан шатны баримтын иж бүрдэлгүй болон дутуу байна. Сайдын 2024 оны 2025 оны I улирлын байдлаар 60,638.7 сая төгрөгийн 511 тушаалын 21790,26 сая төгрөгийн 250 тушаал санхүүгийн анхан шатны баримтын иж бүрдэл дутуу байна.</p> <p>Дээр тушаалаудаас гадаад томилолтын зардлыг түүвэрлэн авч үзэхэд Сайдын 54,710.8 мянган төгрөгийн 5 тушаал, ТНБД-ын 173,028.0 мянган төгрөгийн 3 тушаал, сайдаас эрх шилжүүлж зардал баталсан 19,898.7 мянган төгрөгийн 1 тушаал буюу нийт 247,637.50 мянган төгрөгийн нийт 9 тушаал санхүүгийн анхан шатны баримтгүй, үйл ажиллагааны тайлангүй, төсөвлөсөн зардал гүйцэтгэлээрх зардал зөрүүтэй зөрчил илэрсэн байна.</p>	6-р сар	80%	
1.2. САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ								
5	Арга хэмжээ 2.1. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, удирдах тушаалтны шийдвэрийн төлөвлөгөөт дотоод шалгалт хийх.	Гомдолын шийдвэрлэлтийн хувь	ЗГХЭГ, ЗГХХГ, иргээдээс ирүүлсэн өргөдөл гомдол-10	100%	<p>Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, хүсэлт, удирдах албан тушаалтны шийдвэрийн дагуу 6 төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэн нийт 38,026.27 мянган төгрөгийн 21 зөрчил илрүүлж 4,430,6 мянган төгрөгийн төлбөрийн акт-2, 1,6434.47 мянган төгрөгийн албан шаардлага-1, 31,961.2 мянган төгрөгийн 18 зөвлөмж, 2 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлсэн. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Дотоод хяналт шалгалтаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт 75%-тай байна.</p>	6-р сар, 12-р сар	100%	

Хавсралт: 5 файл

6	Арга хэмжээ 2.2. Дорнод, Хэнтий, Баян-Өлгий, Увс аймгийн СУАЖГ, БСТГ, театр, музей, номын сан, соёлын төвд дотоод хяналт, шалгалтыг төлөвшүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Дотоод хяналт, шалгалтын журам батлуулсан, хяналт, шалгалтын ажилтан томилсон байгууллагын Тоо Хамрагдсан хүний тоо	Дотоод хяналт, шалгалтын журам батлуулсан, хяналт, шалгалтын ажилтан томилсон байгууллагын тоо-420	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн үйцэтгэлийн төлөвлөгөөний 24-т тусгасан арга хэмжээний дагуу Баян-Өлгий, Увс, Хэнтий, Дорнод, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн харьяа байгууллагуудын 360 албан хаагчдад дотоод хяналт шалгалтын чиглэлээр сургалт зохион байгуулахын хөтөлбөрийг боловсруулсан. Хөтөлбөрөөр дотоод хяналт шалгалт хийх, шилэн дансны бүртгэл хөтлөлт хэрэгжилтэд хяналт хийх, дээд байгууллагаас болон хөндлөнгийн байгууллагаас хургуулсан санхүүгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг тайлгахаас тухай сэдвээр арга зүйг эзэмшишүүлэх онол, дадлага ажлыг сургалтаар олгохоор төлөвлөсөн. Хөтөлбөр, томилолтоор ажиллах тушаалыг сайдаас төрийн нарийн бичгийн дарга луу эрх шилжүүлхээр шийдвэрлэсэн. Мөн зүүн бүсийн удирдах ажилтын зөвлөгөөнтэй уялдуулан зохион байгуулахаар хүлээгдэж байна	Хавсралт: 1 файл	6-р сар, 12-р сар	30%
